



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.6, 6.6, 6.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.”Дорноговь-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өргөө нөхсөн, 2 нэрийн, нийт 235,420,503.00 (хоёр зуун гучин таван сая дөрвөн зуун хорин мянга таван зуун гурав) төгрөгийн балансын үнэ, 182,952,294.00 (нэг зуун наян хоёр сая есөн зуун тавин хоёр мянга хоёр зуун ерэн дөрөв) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, “Дорноговь-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал А.Баттогтох нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, эргэлтийн хөрөнгөд орлого авч бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Акталж данснаас хассан тээврийн хэрэгслийг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Нарангэрэл

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2021 оны 06
дугаар сарын 25...-ний өдрийн 13
дугаар тогтоолын хавсралт

**"Дорноговь-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Ашиглал тад орсон он	Тоо хэм жээ	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэгдэл өртөг /төгрөг/
1	XCMG GR-135 маркийн, 38-83 ДО улсын дугаартай, автогрейдер, арлын дугаар- G13500311057	2009	1	81,225,000.0	81,225,000.0	0.0
2	Лабраторын барилга /Айраг сум дахь кемп/	2012	1	154,195,503.0	101,727,294.0	52,468,209.0
			2	235,420,503.0	182,952,294.0	52,468,209.0
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			235,420,503.00 (хоёр зуун гучин таван сая дөрвөн зуун хорин мянга таван зуун гурав)	182,952,294.00 (нэг зуун наян хоёр сая есөн зуун тавин хоёр мянга хоёр зуун ерэн дөрөв)	52,274,721.00 (тавин хоёр сая хоёр зуун далан дөрвөн мянга долоон зуун хорин нэгэн)